



**Улсын Их Хурлын Байгаль орчин, Хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо, Байгаль орчны яам, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар хамтран зохион байгуулсан “Ашигт малтмалын хууль дахь байгаль орчны асуудал” хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж**

2006 оны 4 дүгээр сарын 10

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлаас “Ашигт малтмалын тухай хууль”- ийг 1997 онд баталж түүнийг мөрдөж ажилласаар багагүй хугацаа өнгөрсөн байна. Энэ хууль нь геологи, уул уурхайн салбарт гадаад дотоодын шууд хөрөнгө оруулалтыг өргөнөөр татах, ялангуяа геологийн судалгаа болон эрэл хайгуулын ажилд хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн байна. “Ашигт малтмалын тухай хууль”-ийг хэрэгжүүлж ирсэн практикаас харахад зарим эрх зүйн зохицуулалтыг шинэ шатанд гаргах шаардлага амьдралаас урган гарсаар байна.

Геологи уул уурхайн салбарын улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах цаашдын хувь хэмжээг нэмэгдүүлэх үүднээс хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг цаашид боловсронгуй болгох, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Дээрх үр дагаврыг харгалзан практик амьдралд гарч буй зарим харилцааг боловсронгуй болгох чиглэлээр нэмэлт, өөрчлөлийг хуульд оруулах шаардлагатай юм.

Монгол улсын нутаг дэвсгэр дээр 2005 оны байдлаар 198 уурхайн үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 135 алтны шороон орд, 17 нүүрсний уурхай, 10 хайлуур жоншны, 24 барилгын материалын үйлдвэрийн түүхий эд олборлох уурхайнууд байна. Манай улсын нутаг дэвсгэрийн 43% нь хайгуулын зөвшөөрөлд хамрагдсан гэсэн албан ёсны тоо баримт байна. 2006 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 6073 лиценз олгогдсноос 5097 хайгуулын, 976 ашиглалтын лиценз байна. 2005 оны жилийн эцсийн мэдээгээр нийт 198 уурхай ажиллаж нийт 5411 га талбай олборлолтонд хамрагдан эвдрэснээс 2356,6 гад нөхөн сэргээлт хийсэн байна.

Ашигт малтмалын хууль ба байгаль орчны асуудал хэлэлцүүлэгт оролцогсод одоогийн ашигт малтмалын хуулийн хүрээнд хайгуулын болон ашиглалтын лицензи олгож буй байдал, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх асуудал туйлын хангалтгүй байгаа байдал, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох үүднээс дор дурьдсан чиглэлээр дараахь зөвлөмжийг гаргаж байна.

### **Хайгуулын лиценз олгоход санал өгөх**

- Хайгуулын лиценз олгоход Аймгийн Засаг дарга нь аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ болон түүн дээр үндэслэн боловсруулсан хайгуулын нийт хугацаанд хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг үндэслэн саналаа өгдөг байх

### **Хайгуулын явц дахь байгаль хамгаалах арга хэмжээ**

- Хайгуулын лиценз эзэмшигч нь тухайн жилд хийх хайгуулын ажлын төлөвлөгөө, байгаль хамгаалах төлөвлөгөөгөө сумын Засаг даргаар батлуулж гүйцэтгэлийг нь жилийн эцэст сумын ИТХ ба ерөнхий үнэлгээ хийсэн газарт тайлагнадаг байна
- Тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх барьцааны хөрөнгийг сумын дэргэдэх тусгай дансанд төвлөрүүлж холбогдох газруудын дүгнэлтэнд үндэслэн буцаан олгох шийдвэрийг ерөнхий үнэлгээ хийсэн газар гаргана. Барьцааны хөрөнгийг шилжүүлээгүй тохиолдолд хайгуулын үйл ажиллагаа явуулахыг хориглоно
- Сумын байгаль орчны улсын байцаагч нь тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана

### **Хариуцлагын тогтолцоо**

- Хайгуулийн лицензийг шинээр нэмж авах, сунгах, бусдад шилжүүлэх тохиолдолд эрх бүхий байгууллагаар (сумын ИТХ-ын шийдвэр, ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын тодорхойлолт) баталгаажуулсан жил бүрийн байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хавсаргах ба байгаль хамгаалах үүргээ хангалтгүй биелүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжид нэмж хайгуулын талбай олгохгүй байх ба лицензийг сунгуулах, бусдад шилжүүлэх асуудлыг хайгуулын явцад байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх хүртэл авч үзэхгүй байх
- Хайгуулын лицензийг цуцласан тохиолдолд лиценз эзэмшигч нь байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулах хариуцлагаас чөлөөлөгдөхгүй байх

### **Хөндлөнгийн хяналт, ил тод байдал**

- Хайгуулын лицензтэй холбогдолтой нууцад хамаарахгүй бүх мэдээллийг БОЯ, ашигт малтмалын хэрэг эрхлэх газар болон бусад хариуцсан байгууллага болон холбогдох байгууллагын интернетийн хуудсаар дамжуулан нийтэд хүртээмжтэй болгох ба шаардлагатай нэмэлт мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх

### **Ашиглалтын лиценз олгоход санал өгөх**

- Сумын ИТХ-ын шийдвэр, тухайн төслийн Техник эдийн засгийн үндэслэл, БОНБ-ын нарийвчилсан үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, аймаг сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн аймгийн Засаг дарга саналаа өгнө.

### **Ашиглалтын лиценз олгоход тавигдах шаардлага**

- Байгаль орчныг нөхөн сэргээх техник, эдийн засгийн чадвартай байх
- Уурхайн ашиглалт, түүний нөхөн сэргээлтийн зардал нь цэвэр ашигаас их буюу эдийн засгийн хувьд бага ашигтай ордуудад ашиглалтын лиценз олгохгүй байх
- Лиценз олгож болохгүй газруудыг хуульчлах Үүнд: экологийн эмзэг газар буюу гол мөрний эх, нуурын ай сав газарт 40 км-ийн радиуст, нэн ховор амьтан, ургамлын байршил газар болон төв, суурин, түүх соёлын дурсгалт газрууд

### **Ашиглалтын явц дахь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа**

- Жил бүрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, уулын ажлын төлөвлөгөөг БОЯ, УМХГ, АМХЭГ-аар батлуулж гүйцэтгэлийг нь тухайн жилийн 12-р сард багтаан аймаг, сумын ИТХ болон холбогдох газруудад тайлагнадаг байх
- Тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх барьцааны хөрөнгийг сумын дэргэдэх тусгай дансанд төвлөрүүлж холбогдох газруудын дүгнэлтэнд үндэслэн буцаан олгох шийдвэрийг БОЯ олгоно (сумын биш БОЯ-ны дэргэдэх тусгай данстай болох). Барьцааны хөрөнгийг шилжүүлээгүй тохиолдолд уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Лиценз авахдаа 50% хийж байж авах
- УМХГ, аймаг сумын байгаль орчны байцаагчид байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана

### **Хариуцлагын тогтолцоо**

- Тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөө, хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан ажлын 50 хүртэлх хувийг хэрэгжүүлээгүй тохиолдолд ашиглалтын лицензийг цуцлах ба хохирлыг барагдуулах хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

- Ашиглалтын лиценз сунгах, шинээр нэмж авах, шилжүүлэх тохиолдолд эрх бүхий байгууллагаар (Аймаг сумын ИТХ-ын шийдвэр, УМХГ, БОЯ, АШМХГ) баталгаажуулсан жил бүрийн байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хавсаргах ба байгаль хамгаалах үүргээ хангалтгүй биелүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжид ашиглалтын лиценз олгохгүй байх, лицензийг сунгуулах, бусдад шилжүүлэх асуудлыг ашиглалтын явцад байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх хүртэл авч үзэхгүй байх. Байгаль орчны төлөвлөгөө, техник эдийн засгийн үнэлгээг ҮХЯ зөвшөөрөх, БОЯ, УМХГ батлах. (хамтарч батлах)
- Байгаль орчны болон ашигт малтмалын хууль тогтоомж зөрчсөнд оногдуулах торгуулын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хэд дахин нугалж оногдуулах. Ашигт малтмалын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дахь энэ зүйлд заасан захиргааны хариуцлагын хэмжээнээс хэтрэхгүй байна гэсэн заалтыг хасах
- Байгаль орчинд хохирол учруулсан эрүүгийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, хохирол арилгах хүртэл үргэлжилдэг болгох
- 52 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт 5 дахь заалт болгон нэмэлт оруулах шаардлагагүй.
- Лиценз олгохдоо дутуу баримтыг бичгийг үндэслэсэн бол тухайн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 нугалсантай тэнцэх хэмжээгээр торгох ба лицензийг хүчингүйд тооцох

#### **Хөндлөнгийн хяналт, ил тод байдал**

- Ашиглалтын лицензтэй холбогдолтой нууцад хамаарахгүй бүх мэдээллийг БОЯ, АМХЭГ болон холбогдох байгууллагын интернетийн хуудсаар дамжуулан нийтэд хүртээмжтэй болгох ба шаардлагатай нэмэлт мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх

#### **Тогтвортой байдлын гэрээ:**

**50 сая доллартай тэнцэх хөрөнгө оруулалтай гадаад, дотоодын аж ахуйн нэгж байгууллага ТБГ-г хийнэ.**

- Тогтвортой байдлын гэрээнд байгаль хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой заалтуудыг дэлгэрэнгүй тусгадаг байх
- Тогтвортой байдлын гэрээг боловсруулах, байгуулахад Үндэсний баг ажиллах бөгөөд бүрэлдэхүүний бүрэлдэхүүнд ТББ, эрдэмтэд, нутгийн иргэдийн төлөөлөлийг оруулна.

Энэ хуультай холбогдуулаад бусад хууль эрх зүйн актуудад нэмэлт өөрчлөлт оруулна. Үүнд:

### **Дагалдан гарах дүрэм журам, стандарт, норм**

#### **АМХЭГ, БОЯ:**

Нөхөн сэргээлт: нөхөн сэргээлтийн зохих стандарт шаардлагын дагуу хийнэ.

- Ашигт малтмалын төрөл болон геологи, ашиглалтын нөхцөлд тохирсон нөхөн сэргээлтийн аргачилал, стандартыг боловсруулж мөрдүүлэх
- Ашигт малтмалыг зүй зохистой, ариг гамтай ашиглах зорилгоор олборлолт ба боловсруулалтын үеийн технологийн хаягдлын нормыг стандартыг тогтоож мөрдүүлэх
- Эвдэрсэн газрын хэвлий болон талхлагдсан газрын гадаргуугын хэмжээг талбай болон эзлэхүүнээр ашигт малтмалын төрөл уурхай тус бүрээр нэгтгэн жил бүр улсын нэгдсэн тоо бүртгэлд хамруулна
- Экологи, эдийн засгийн үнэлгээ, байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээг тооцох аргачлал боловсруулж мөрдүүлэх

### **Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний хуулинд оруулах санал**

- Тухайн компани голын ай савд үйлдвэрлэл эрхэлсэн тохиолдолд тухайн гол мөрний сав газрын стратегийн суурь үнэлгээг БОНБУ-тэй уялдуулах. (стратегийн суурь үнэлгээ)
- БОНБ-ын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний тайланг олон нийтэд танилцуулах процедурыг тодорхой болгож хуульчлах
- Иргэдийн саналыг аваагүй, саналыг үндэслэлгүй шийдвэр гаргасан тохиолдолд хариуцлага тооцох
- Гаргасан шийдвэрийг нийтэд танилцуулах
- БОНБНУ хийгээгүй ААНБ-д үнэлгээ хийхэд шаардлагатай зардлыг 2 дахин нэмэгдүүлж тооцох
- БОНБНУ хийсэн аж ахуйн нэгж нь 2 жил тутамд зохиогчийн хяналт тавих үүрэгтэй бөгөөд гаргасан дүгнэлтээ байгаль орчны болон мэргэжлийн хяналтын төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

### **Хэлэлцүүлэгт оролцогчид**